



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/367

Улаанбаатар хот

Г Магадлан итгэмжлэл олгох тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн арван зургаадугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141224554

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
10 сарын 17-ны өдрийн 4/367
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Ундрах ирээдүй өрхийн эрүүл мэндийн төв	260/2023	2 жил	2023.10.27	2025.10.27
2.	Улаанбаатар хот, АШУУИС-ийн Нүүр, ам судлалын сургууль	261/2023	1 жил	2023.10.17	2024.10.17
3.	Нийслэлийн түргэн тусламжийн төв	262/2023	4 жил	2023.10.29	2027.10.29
4.	Улаанбаатар хот, Дөлгөөн амьдрал ХХК-ийн Нэгдсэн эмнэлэг	263/2023	1 жил	2023.10.29	2024.10.29
5.	Улаанбаатар хот, Ливерген ХХК-ийн эмнэлэг	264/2023	1 жил	2023.10.17	2024.10.17
6.	Улаанбаатар хот, Сор наран мед ХХК-ийн эмнэлэг	265/2023	1 жил	2023.10.17	2024.10.17
7.	Улаанбаатар хот, Фамили клиник медиал ХХК-ийн эмнэлэг	266/2023	1 жил	2023.10.17	2024.10.17
8.	Дорноговь аймаг, Айраг сумын эрүүл мэндийн төв	267/2023	2 жил	2023.11.01	2025.11.01
9.	Дорноговь аймаг, Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төв	268/2023	2 жил	2023.10.19	2025.10.19
10.	Дорнод аймаг, Уламжлалт анагаах ухааны төв	269/2023	3 жил	2024.01.05	2027.01.05
11.	Орхон аймаг, Их тавт ХХК-ийн "Их тавт" эмнэлэг	270/2023	3 жил	2023.10.29	2026.10.29
12.	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төв	271/2023	2 жил	2024.01.01	2026.01.01